



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 11641

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Чингэлтэй дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2. Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

1725023028

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
 05 сарын 06-ны өдрийн
 захирамжийн
 хавсралт

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ**

(сая төгрөг)

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
1	XIV.1.1.171	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/	2018	2025	4,217.9	582.5
ДҮН					4,217.9	582.5

ବୁଦ୍ଧିମତ୍ତାରେ କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା

Digitized by srujanika@gmail.com

(၁၁။ ၁၀၃၁။) - ၂၇ ၁၀၁၈ ၁၀၁၈ ၁၀၁၈

ପ୍ରକାଶ ମୁଦ୍ରଣ କମିଶନ୍ ପରିଷଦ୍ ରେ ଏହାର ଅଧିକାରୀ ପରିଷଦ୍ ରେ ଏହାର ଅଧିକାରୀ

ଶ୍ରୀ ପାତ୍ରଜୀର୍ଦ୍ଧ ପତ୍ର

$$\frac{\sin \theta}{\sin \theta} = \frac{1}{1}$$

मुख्य

ପ୍ରକାଶମାଲା



የኢትዮጵያ
የኢትዮጵያ ማኅበር ተስፋዎች እና የንግድ